

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/64/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 09/146
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ӨЛЗИЙБУЯН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага тайлант онд Баяр наадмын зардалд шилжих үлдэгдлээс 24,500.0 мянган төгрөгийг нэмж батлуулж, хурдан морины бай шагналд 6 ширхэг мотоциклыг 15,900.0 мянган төгрөгөөр худалдан авч шагнасан, шилжих үлдэгдлээс 27,600.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй худалдан авсан, гадаад албан томилолтын зардал батлагдаагүй байхад 2,776.0 мянган төгрөгийн онгоцны билетийг төсвөөс худалдан авсан, Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой газрын дуудлага худалдааны орлого 44,700.0 мянган төгрөгөөс худалдан авах ажиллагаа зарлалгүй техник эдийн засгийн үндэслэлгүй гэрээ байгуулж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр 35,000.0 мянган төгрөгийг оны эцэст 100 хувь шилжүүлсэн нийт 81,286.0 мянган төгрөгийн зөрчил гаргасан нь гүйцэтгэлийн үе шатны материаллаг түвшнээс хэтэрсэн буюу санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд 2 хөтөлбөр 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 486,142.5 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 91 хувьтай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Борнуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 202,258.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгийн шилжих үлдэгдлээр баталсан байна. Үүнээс 35,000.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөцөд, 5,000.0 мянган төгрөгийг нутгийн өөрөө удирдах байгууллагын ой тэмдэглэхэд, 24,500.0 мянган төгрөгийг сумын баяр наадамд, 50,000.0 мянган төгрөгийг тавилга худалдан авахад тус тус баталсан нь төсвийг үр ашиггүй зарцуулах, тайлант онд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсэх, хууль тогтоомж зөрчигдөх шалтгаан болсон байна.
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой газрын дуудлага худалдааны орлого 44,700.0 мянган төгрөгөөс худалдан авах ажиллагаа зарлалгүй шууд гэрээ байгуулж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр 35,000.0 мянган төгрөгийг гүйцэтгэлийг хүлээж авалгүй оны эцэст 100 хувь шилжүүлсэн байна.
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой түрээсийн орлого, архивын лавлагааны орлого, газрын дуудлага худалдааны орлогууд болох 14,083.9 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,389,243.00	75,176,508.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	20,665.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	20,665.00
31110	Төгрөг	00.00	20,665.00
33	АВЛАГА	00.00	35,300,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	300,000.00
335	Бусад авлага	00.00	35,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	35,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,389,243.00	39,855,843.00
351	Түүхий эд материал	235,140.00	235,140.00
35110	Тусгай зориулалттай материал	235,140.00	235,140.00
354	Хангамжийн материал	39,154,103.00	39,620,703.00
35420	Аж ахуйн материал	37,566,603.00	35,548,203.00
35470	Бусад хангамжийн материал	1,587,500.00	4,072,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,914,488,549.77	4,524,170,781.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,914,488,549.77	4,524,170,781.18
392	Биет хөрөнгө	3,828,314,549.77	4,437,996,781.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,215,299.39	323,215,299.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-187,466,440.63	-211,026,378.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,407,955.00	416,497,338.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-103,012,026.68	-135,256,823.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,172,028.60	125,429,328.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,673,894.16	-64,097,511.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,231,726.68	95,139,426.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,866,831.30	-42,159,542.35
39209	Зам, гүүрийн байгууламж	1,378,984,143.00	1,378,984,143.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-36,389,859.25	-59,372,928.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,531,377,341.50	4,085,267,224.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,304,664,892.38	-1,474,622,795.52
393	Биет бус хөрөнгө	86,174,000.00	86,174,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	85,624,000.00	85,624,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,953,877,792.77	4,599,347,289.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,953,877,792.77	4,599,347,289.18
51	Засгийн газрын хувь оролцоо	3,953,877,792.77	1,451,938,176.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,451,938,176.48	1,451,938,176.48
51101	Өмч: - төрийн	1,451,938,176.48	1,451,938,176.48
512	Хуримтлагдсан үр дүн	2,326,938,856.52	2,972,408,352.93
51210	Өмнөх үеийн үр дүн	2,326,938,856.52	2,326,938,856.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	645,469,496.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,000,759.77	175,000,759.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,953,877,792.77	4,599,347,289.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	734,343,512.50	1,466,258,724.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,946,500.00	835,527,266.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,892,500.00	547,115,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,728,100.00	547,115,450.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,728,100.00	547,115,450.00
120009	Бусад орлого	164,400.00	00.00
122	Тусламжийн орлого	114,054,000.00	288,411,816.00
122001	Хандив тусламж /дотоод/	114,054,000.00	288,411,816.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,397,012.50	630,731,458.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,863,100.00	550,334,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	480,863,100.00	550,334,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,533,912.50	80,397,158.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,533,912.50	80,397,158.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	770,856,521.27	820,789,227.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,727,021.27	820,789,227.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,754,238.86	790,972,918.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,586,415.23	232,291,678.93
210101	Үндсэн цалин	170,146,424.91	176,333,151.70
210102	Нэмэгдэл	56,769,500.00	44,652,413.93
210104	Урамшуулал	00.00	11,306,113.30
210105	Гэрээт ажлын хөлс	23,670,490.32	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,905,053.25	27,224,510.75
210201	Тэтгэврийн даатгал	23,944,272.54	19,042,739.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,489,795.37	2,048,538.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,992,516.27	1,638,831.32
210204	Ажилгүйдлийн даатгал	496,929.68	408,581.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,981,539.39	4,085,819.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,743,021.30	40,775,776.47
210301	Гэрэл, цахилгаан	4,948,478.30	5,033,900.00
210302	Түлш, халаалт	32,673,143.00	35,611,876.47
210303	Цэвэр, бохир ус	121,400.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,290,860.00	56,743,760.00
210401	Бичиг хэрэг	2,163,100.00	2,180,250.00
210402	Тээвэр, шатахуун	22,296,960.00	23,144,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,487,000.00	1,608,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,343,800.00	29,810,850.00
2105	Нормативт зардал	3,635,070.00	00.00
210502	Хоол, хүнс	2,175,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,460,070.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,636,000.00	2,798,000.00
210702	Дотоод албан томилолт	1,636,000.00	2,798,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,832,769.00	31,175,349.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,774,619.00	29,255,354.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	419,995.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	338,150.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,125,050.08	398,463,842.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,477,405.00	121,983,808.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	227,647,645.08	276,480,034.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,972,782.41	29,816,309.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	9,083,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	9,083,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,972,782.41	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,972,782.41	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	20,732,409.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,051,059.19
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,681,350.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,129,500.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,129,500.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	38,073,500.00	00.00
223001	Бусад хөрөнгө	9,056,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-36,513,008.77	645,469,496.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-36,513,008.77	645,469,496.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	551,397,012.50	630,731,458.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,397,012.50	630,731,458.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	480,863,100.00	550,334,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	480,863,100.00	550,334,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,533,912.50	80,397,158.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,533,912.50	80,397,158.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	487,271,042.50	577,590,793.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,271,042.50	577,590,793.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,298,260.09	547,774,483.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,989,666.53	232,591,678.93
210101	Үндсэн цалин	171,549,676.21	176,633,151.70
210102	Нэмэгдэл	56,769,500.00	44,652,413.93
210104	Урамшуулал	00.00	11,306,113.30
210105	Гэрээт ажлын хөлс	23,670,490.32	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,905,053.26	27,224,510.75
210201	Тэтгэврийн даатгал	23,944,272.55	19,042,739.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,489,795.37	2,048,538.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,992,516.27	1,638,831.32

210204	Ажилгүйдлийн даатгал	498,079.08	408,581.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,980,389.99	4,085,819.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,943,621.30	40,775,776.47
210301	Гэрэл, цахилгаан	4,948,478.30	5,033,900.00
210302	Түлш, халаалт	34,865,143.00	35,611,876.47
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,071,200.00	41,124,350.00
210401	Бичиг хэрэг	2,352,500.00	2,180,250.00
210402	Тээвэр, шатахуун	11,620,700.00	10,336,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	1,608,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,490,000.00	27,000,000.00
2105	Нормативт зардал	3,659,000.00	00.00
210502	Хоол, хүнс	2,175,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,484,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,708,000.00	2,798,000.00
210702	Дотоод албан томилолт	1,708,000.00	2,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,020,966.00	31,175,354.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,962,816.00	29,255,354.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	420,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	338,150.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,500,753.00	170,584,813.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,370,753.00	170,584,813.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,972,782.41	29,816,309.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	9,083,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	9,083,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,972,782.41	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,972,782.41	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	20,732,409.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,051,059.19
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,681,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>64,125,970.00</u>	<u>53,140,665.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>64,128,600.00</u>	<u>53,120,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>64,128,600.00</u>	<u>53,120,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	64,128,600.00	53,120,000.00
222001	Тоног төхөөрөмж	38,665,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	9,056,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,407,600.00	53,120,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-64,128,600.00</u>	<u>-53,120,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2,630.00	20,665.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,630.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	20,665.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,326,938,856.52	00.00	3,953,877,792.77
D01	2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,326,938,856.52	00.00	3,953,877,792.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,326,938,856.52	00.00	3,953,877,792.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	645,469,496.41	00.00	646,269,496.41
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,972,408,352.93	00.00	4,599,347,289.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	550,334,300.00	539,283,240.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,334,300.00	539,283,240.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	550,334,300.00	539,283,240.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,928,600.00	232,591,678.93
210101	Үндсэн цалин	178,139,400.00	176,633,151.70
210102	Нэмэгдэл	58,789,200.00	54,064,815.23
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,893,712.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,985,200.00	27,224,510.75
210201	Тэтгэврийн даатгал	22,508,200.00	19,042,739.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,369,300.00	2,048,538.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,895,400.00	1,638,831.32
210204	Ажилгүйдлийн даатгал	473,800.00	408,581.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,738,500.00	4,085,819.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,591,900.00	40,775,776.47
210301	Гэрэл, цахилгаан	5,033,900.00	5,033,900.00
210302	Түлш, халаалт	36,428,000.00	35,611,876.47
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,353,700.00	37,353,700.00
210401	Бичиг хэрэг	1,176,000.00	1,176,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,569,700.00	7,569,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	1,608,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,000,000.00	27,000,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,806,700.00	2,798,000.00
210702	Дотоод албан томилолт	2,806,700.00	2,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,217,300.00	31,175,354.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,297,300.00	29,255,354.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	420,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,950,900.00	165,864,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,950,900.00	165,864,220.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	550,334,300.00	550,334,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,334,300.00	550,334,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	550,334,300.00	539,283,240.81
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,665.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,803,969.00	70,715,808.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,803,969.00	70,715,808.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,803,969.00	61,631,908.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,051,000.00	3,770,650.00
210401	Бичиг хэрэг		1,004,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,051,000.00	2,766,400.00
2105	Нормативт зардал	3,059,000.00	-
210502	Хоол, хүнс	2,175,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	884,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,960,186.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,960,186.00	

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,733,783.00	57,861,258.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,603,783.00	57,861,258.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	9,083,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		9,083,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		9,083,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	80,397,158.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		80,397,158.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,801,339.00	80,397,158.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,630.00	

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг тасралтгүй чанартай хүргэж, төр засгийн бодлого шийдвэрийн дагуу орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах, сурч боловсрох, эрүүл аж төрөх нөхцөлөөр хангах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын тогтвортой хөгжлийн өсөлтийг хангах зорилгоор улс, аймаг, сумын болон хувийн хэвшлийн төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар иргэдийн ажилтай орлоготой чанартай амьдрах орчин нөхцөлийг хангах бүхий л арга хэмжээг идэвхитэй явуулах
- Боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний хүрсэн түвшинг ахиулах
- Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх санг зориулалтын дагуу зарцуулж, иргэдийн оролцоо, хяналтыг ханган, сумын хэмжээнд бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг хөгжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, хэрэгжүүлэх 16 арга хэмжээтэй баталснаас нийт 91,0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тамгын газрын даргын 2021 оны А/20 дугаар тушаалаар дотоод хяналт, шалгалтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 645,469.5 мянган төгрөгөөр буюу 16,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	20.6	20.6
Авлага	0.0	35,300.0	35,300.0
Бараа материал	39,389.2	39,855.8	466.6
Үндсэн хөрөнгө	3,914,488.5	4,524,170.7	609,682.2
Нийт хөрөнгө	3,953,877.7	4,599,347.2	645,469.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,953,877.7	4,599,347.2	645,469.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,953,877.7	4,599,347.2	645,469.5

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага данс эцсийн үлдэгдэл 35,300.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь оны эцэст "Ланд Овнер" ХХК-тай гэрээ байгуулж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр 35.0 сая төгрөгийг оны эцэст шилжүүлэн авлага үүсгэснээс шалтгаалсан байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 39,389.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 39,855.8 мянган төгрөг болж 466.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн худалдан авсан аж ахуйн бараа материалтай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 3,914,488.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 4,524,170.7 мянган төгрөг болж, 609,682.2 мянган төгрөгөөр өссөн нь шилжих үлдэгдлээс худалдан авсан хөрөнгө болон хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,599,347.2 мянган төгрөг болж 645,469.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 476,268.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 74,066.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2022 оны урсгал зардлын төсвийг 550,334.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 550,334.3 мянган төгрөгөөс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 550,334.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 539,283.1 мянган төгрөгийг зарцуулж 11,051.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 539,283.1 мянган төгрөг буюу 98,0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	376,491.3	367,685.4	8,805.8	97.6%

2	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	30,297.3	29,255.3	1,042.0	96.5%
3	70106/80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	53,746.7	52,543.4	1,203.2	97.7%
4	70106/81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0	40,000.0	0.0	100.0%
5	71411/82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг	27,000.0	27,000.0	0.0	100.0%
6	70106/82801 Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100.0%
7	71411/81701 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	17,799.0	17,799.0	0.0	100.0%
	ДҮН	550,334.3	539,283.1	11,051.0	98.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд усны орлого 4,292.2 мянган төгрөг, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдын тэтгэмж 9,083.9 мянган төгрөг, мал тооллогын зардал 6,099.2 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх шатахууны зардалд 1,166.4 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлтийн тоглоомын талбай байгуулах, хогийн цэгийн цэгцлэх, залуусын орон сууц барилгын ажил, нийтийн бие засах газар, хими цэвэрлэгээний газрын барилгын ажлын захиалагчийн хяналтын зардал 6,190.1 мянган төгрөг, ажил зуучлалын зардал 141.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны төлбөр 54,270.5 мянган төгрөг, хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны зардал 160.0 мянган төгрөг, түрээсийн орлого 3,150.0 мянган төгрөг, өөрийн орлого 256.0 мянган төгрөг, цахим тендерийн орлого 630.0 мянган төгрөг, өвсний үнэ 2,300.0 мянган төгрөг, нийт 87,741.3 мянган төгрөгийн орлого орсноос орон нутгийн орлогод 7,344.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,004.2 мянган төгрөг, тээвэр шатахуунд 2,766.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 57,861.2 мянган төгрөг, тэтгэмжид 9,083.9 мянган төгрөг, нийт 78,060.0 мянган төгрөгийг зарцуулж, 9,681.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 91.0 %	550,334.3	539,283.1

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 03/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 734,343.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,015.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,261.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад хөрөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн шийдвэрүүд, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээнүүдийг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоосныг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,785.4	1	3,785.4	100%
Албан шаардлага	1	16,457.6	1	16,457.6	100%
Зөвлөмж	2	15,000.0	2	15,000.0	100%
Нийт дүн	4	35,243.0	4	35,243.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засаг даргын нөөцийн зарцуулалтыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 41,070.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлант хугацаанд 6,070.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр "Ланд Овнер" ХХК-тай гэрээ байгуулж 35,000.0 мянган төгрөгийг оны эцэст шилжүүлэн авлага үүсгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгэр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.2 Төлбөрийн акт

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой түрээсийн орлого, архивын лавлагааны орлого, газрын дуудлага худалдааны орлого 14,083.9 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-д "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Гадаад албан томилолтын зардал батлагдаагүй байхад төсвөөс 2,776.0 мянган төгрөгөөр онгоцны билет худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

1. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 70,202.7 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015

“Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Төсөвт төвлөрүүлэх ёстой газрын дуудлага худалдааны орлого 44,753.4 мянган төгрөгөөс худалдан авах ажиллагаа явуулалгүй “Ланд Овнер” ХХК-тай техник эдийн засгийн үндэслэлгүй гэрээ байгуулж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр 35,000.0 мянган төгрөгийг оны эцэст шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 23 дугаар зүйлийн 23.11-д “Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны цэсэд хөрөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн шийдвэрүүд, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээнүүдийг мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4. Шилжих үлдэгдлээс 27,610.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авах ажиллагаа зарлалгүй худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5. Баяр наадмын зардалд шилжих үлдэгдлээс 24,500.0 мянган төгрөгийг нэмж батлуулж, хурдан морины бай шагналд 6 ширхэг мотоциклыг 15,900.0 мянган төгрөгөөр худалдан авч шагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах

зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

6. Засаг даргын нөөцөөс ямар үйл ажиллагаанд зарцуулах нь тодорхойгүй захирамжаар урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой урсгал зардалд 26,082.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын кассаар нийт 18,184.7 мянган төгрөгийг бэлнээр гарган зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6.3-д “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ-500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдсон	1	6,070.3	1	6,070.3			1	6,070.3				
Авлага тусгаагүй	1	35,000.0	1	35,000.0			1	35,000.0				
Дүн	2	41,070.3	2	41,070.3			2	41,070.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ёстой орлогуудыг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.	1	14,083.9	1	14,083.9								
Гадаад албан томилолтын зардал батлагдаагүй байхад онгоцны билет төсвөөс худалдан авсан.	1	2,776.0	1	2,776.0								
Засаг даргын нөөцөөс ямар үйл ажиллагаанд зарцуулах нь тодорхойгүй захирамжаар урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой урсгал	1	26,082.7			1	26,082.7						

зардлуудад зарцуулсан.												
Баяр наадмын зардалд шилжих үлдэгдлээс 24.5 сая төгрөгийг нэмж батлуулж, хурдан морины бай шагналд 6 ширхэг мотоциклыг 15.9 сая төгрөгөөр худалдан авч шагнасан.	1	15,900.0			1	15,900.0						
Шилжих үлдэгдлээс 27.6 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг тендергүй худалдан авсан байна.	1	27,610.0			1	27,610.0						
Худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгахад 70.202.7 мянган төгрөгөөр дутуу байна.	1	70,202.7			1	70,202.7						
Төсөвт төвлөрүүлэх ёстой газрын дуудлага худалдааны орлого 44.7 сая төгрөгөөс худалдан авах ажиллагаа явуулалгүй "Ланд Овнер" ХХК-тай гэрээ байгуулж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр 35.0 сая төгрөгийг оны эцэст шилжүүлсэн байна.	1	35,000.0			1	35,000.0						
Кассаар нийт 18,184.7 мянган төгрөгийг гарган бэлнээр зарцуулсан байна.	1	18,184.7					1	18,184.7				
Дүн	8	209,840.1	2	174,795.4	2	105,411.9	1	18,184.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цэсэд хөрөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн шийдвэрүүд, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээнүүдийг мэдээлээгүй байна.	1.0	0.0			1.0	0.0		
Дүн	1.0	0.0			1.0	0.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1.0	0.0			1.0	0.0		